



# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 04 дугаар сарын 23

№ 01/31

Улаанбаатар хот

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барьцаа хөрөнгийн дансанд 100,000,000.00 төгрөгийн мөнгөн хөрөнгийг 2012 оноос хойш байршуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Барьцаа хөрөнгийн харилцах дансанд байршиж байгаа гэрээ цуцлагдсан хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт 100,000,000.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбат, нягтлан бодогч О.Наранбаатар нарт даалгав.

**ТОГТООСОН:**  
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
 АУДИТОР *Б.Ц.НАРАНЧИМЭГ*  
 АУДИТОР *Б.ЭНХЖИН*

АКТ

**ЗӨВШӨӨРСӨН:**  
 ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН  
 ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА  
 Б.ЧИНБАТ  
 НЯГТЛАН БОДОГЧ  
 О.НАРАНБААТАР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.